



МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙДЫН ТУШААЛ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар A/92

Улаанбаатар хот

Г Журам батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Далай ашиглах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Далбааны эзэн улсын хяналт, шалгалт хийх журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэхүү журмыг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Далайн захиргаа (Д.Отгонсүрэн)-нд, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар (М.Энхболд)-т тус тус үүрэг болгосугай.

САЙД

С.БЯМБАЦОГТ



080000242

ТАНИЛЦУУЛГА

Далбааны эзэн улсын
хяналт, шалгалт хийх журам

Далайн салбарын олон улсын гэрээ конвенц, Монгол Улсын Далай ашиглах тухай хууль, Олон улсын далайн байгууллага /ОУДБ/-ын холбогдох дүрэм, журмын тавигдах шаардлагын дагуу Монгол Улсын төрийн далбаа мандуулан их далайд далайн тээвэр эрхэлж буй хөлөг онгоцуудад Далайн захиргаанаас хяналт, шалгалт явуулж хяналт, шаардлага тавьж ажиллах нь Далбааны эзэн улсын үүрэг, хариуцлага юм.

Далайн эрэг бүхий улсын боомтод нэвтэрч буй хөлөг онгоц бүрт олон улсын гэрээ, конвенцын шаардлагын дагуу боомтын болон хөлөг онгоцны аюулгүй үйл ажиллагааг хангах үүднээс тухайн улсын Боомтын хяналтын албанаас хөлөг онгоцонд үзлэг, шалгалт явуулдаг бөгөөд гол үүрэг нь их далайд аялж буй хөлөг онгоцны техникийн бүрэн бүтэн байдлыг нягтлан шалгах, олон улсын хууль эрх зүйн онгоцны тооноос хамааруулан хар, саарал, цагаан жагсаалт гаргадаг байна.

Далайн эрэг бүхий улсуудын "Боомтын хяналтын" албад хамтран хамтын ажиллагааны санамж бичгийн хүрээнд үзлэг шалгалтад хамрагдсан хөлөг онгоц болон saatuulagdsan хөлөг онгоцны статистик мэдээг жил бүр гаргаж 3 жилийн дундаж дүнгээр далайн тээвэрт оролцогч Далбааны эзэн улсуудыг saatuulagdsan хөлөг онгоцны тооноос хамааруулан хар, саарал, цагаан жагсаалт гаргадаг байна.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоц ихэвчлэн Ази, Номхон далайн бус нутаг (Tokyo MoU) мөн Европ болон Атлантын далайн бус нутагт (Paris MoU) далайн тээврийн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд ихэнхи хөлөг онгоц Токиогийн санамж бичигт нэгдэн орсон боомтын хяналтын албаны үзлэг шалгалтад хамрагддаг байна.

Монгол Улс хөлөг онгоц анх бүртгэж эхэлсэн жилээс буюу 2003 оноос 2023 оны 03 дугаар сар хүртэлх хугацаанд нийт 20 жилийн статистик мэдээллийг авч үзвэл өссөн дүнгээр 4280 гаруй хөлөг онгоц бүртгэсэн бол Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц энэ хугацаанд Токиогийн санамж бичигт нэгдэн орсон улсуудын боомтын хяналтын албанад 2658 удаагийн үзлэг, шалгалтад хамрагдаж, үүнээс 491 хөлөг онгоц saatuulagdsan байна. 2023 оны 01 дүгээр сараас 03 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар 24 удаагийн анхан шатны үзлэг шалгалтад, нийт 38 удаагийн анхан болон давтан шатны үзлэг шалгалтад хамрагдснаас 5 хөлөг онгоц техникийн болон бичиг баримтын зөрчил гарган saatuulagdsan байна, saatuulagdaх болсон шалтгааныг дурьдвал 05105 (MF/HF радио тоног төхөөрөмж), 11101 (Аврах завь), 07106 (Галын аюулгүй байдал), 10109 (Гэрэлтүүлэг, дүрст, дуут

дохионууд), 07115 (Гал унтраах хэрэгсэл), 04114 (Ослын үеийн эрчим хүчний эх үүсвэр - Ослын үед хэрэглэх цахилгаан үүсгүүр), 15109 (Хөлгийн цэвэрлэгээ үйлчилгээ болон тоног төхөөрөмж) гэх мэт кодтой зөрчил гарган холбогдох конвенцын техникийн болон бичиг баримтын бурдлийн шаардлага хангагүй гэх үндэслэлээр саатуулагдсан байна. Эдгээр хөлөг онгоц саатуулагдах болсон зөрчлийг тухай бүр шуурхай арилгуулах арга хэмжээ авснаар дараагийн боомт хүрэх хугацаанд залруулсан ба давтан үзлэг шалгалтаар зөрчлөө арилгасан байна.

Санамж бичигт нэгдэн орсон боомтын хяналтын албаны хар жагсаалтаас гарахын тулд Далбааны эзэн улс буюу Далайн захиргааны зүгээс өндөр насхилттай, өмнө нь зөрчил гаргаж боомтын хяналтын албанц олон удаа саатуулагдсан, холбогдох засвар үйлчилгээг цаг тухайд нь тогтмол хийлгэдэггүй хөлөг онгоцыг өөрийн улсын хөлөг онгоцны бүртгэлд хамруулахгүй байх чиглэлээр ажиллахын зэрэгцээ 2016 оноос эхлэн өөрийн орны хянан шалгагчдыг бэлтгэн, сургаж далбааны эзэн улсын хяналт шалгалтын тоог нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллаж байна.

Олон Улсын Далайн Байгууллагаас гишүүн улсуудад олон улсын гэрээ, конвенцын дагуу хүлээсэн эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй байдалд аудитын шалгалт явуулдаг бөгөөд Монгол Улс далбааны эзэн улсын эрх, үүргээ хэрхэн хэрэгжүүлж буй байдалд 2016 оны 11 дүгээр сард ОУДБ-аас аудитын шалгалт хийсэн. Аудитын шалгалтын дүнгээр багагүй алдаа, дутагдал илэрсэн бөгөөд далайн тээврийн салбарын өндөр хөгжилтэй улсуудтай харьцуулахад далайн салбарын хөгжил эхний үе шатандаа яваа Монгол Улсын хувьд хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, олон улсын гэрээ, конвенцод заасан зайлшгүй биелүүлэх хэм хэмжээг үндэсний хууль, тогтоомждоо тусгах, мэргэжилтэй боловсон хүчний тоог нэмэгдүүлэх, бүртгэлтэй хөлөг онгоцонд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байгааг онцолсон.

Монгол Улс хөлөг онгоцны бүртгэл, хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгон сайжруулах, түүнчлэн хөлөг онгоцны хяналт, шалгалтын тоо, чанарыг нэмэгдүүлэх зорилгоор 2016 оноос эхлэн Далбааны эзэн улсын хяналт шалгалтыг зохих ёсоор хэрэгжүүлэн ажиллаж байна.

Далбааны эзэн улсын хянан шалгагч мэргэжилтнүүдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэх үүднээс 2016 онд ОХУ-д "Далбааны эзэн улс болон бусад орны далбаатай хөлөг онгоцонд үзлэг шалгалт явуулах хянан шалгагч буюу инспектор бэлтгэх" мэргэжил дээшлүүлэх сургалтад 2 мэргэжилтэн, 2019 онд БНХАУ-д 1 мэргэжилтэн далайн тээврийн хөлөг онгоцонд үзлэг шалгалт хэрэгжүүлэх сургалтад тус тус хамрагдсан. Мөн эдгээр хянан шалгагчид нь ОУДБ-аас зохион байгуулдаг хөлөг онгоцны аюулгүй ажиллагаатай холбоотой сургалт, семинар тухай бүр хамрагдаж, тогтмол мэдлэг боловсролоо дээшлүүлэн ажиллаж байна.

2016 оноос 2023 оны хугацаанд Далбааны эзэн улсын хяналт шалгалтыг нийт 30 орчим удаа хийсэн байна. Өнөөдрийн байдлаар Далайн захиргаанаас

томилогдсон далбааны эзэн улсын хянан шалгагч 3 мэргэжилтэн, бусад орны гэрээт 1 хянан шалгагч, нийт 4 хянан шалгагчид Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцуудад хяналт, шалгалт хийж далбааны эзэн улсын эрх үүрэг, үндэсний хууль тогтоомж болон олон улсын гэрээ, конвенцын шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

ОУДБ-ын Ассамблейн A.1070 (28) дугаар тогтоолын дагуу батлагдсан Эрх зүйн актыг хэрэгжүүлэх дүрэм (III code) -ийн 8.1 –д “Улсынхаа далбааг хөлөг онгоцонд мандуулах талаар захиргааны, техникийн болон бусад нөхцөлийг хууль зүйн үүднээс зохицуулалт хийсэн тодорхой хууль тогтоомжийг боловсруулж гаргасан байх, ялангуяа хөлөг онгоц бүртгэх, хяналт шалгалт хийх, хөлөг онгоцны аюулгүй ажиллагаа, бохирдлоос хамгаалахад чиглэсэн хууль тогтоомжийг батлан мөрдөх үүрэгтэй” гэж заасан байна.

Энэхүү үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан үндэсний эрх зүйн акт боловсруулах шаардлагатай тул олон улсын гэрээ, конвенц холбогдо дүрэм журмын шаардлага, ОУДБ-ын аудитын зөвлөмж нь “Далбааны эзэн улсын хяналт, шалгалт хийх журам” -ын төслийг боловсруулах үндэслэл болж байна.

Уг журмын төсөлд Далайн захиргааны Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын алба бусад орны хууль, дүрэм, журам, тогтоол шийдвэрт тулгуурлан судалгаа хийж, холбогдох мэргэжилтийн саналыг авч Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд далбааны эзэн улсын хяналтыг хэрхэн хэрэгжүүлэх, хяналт, шалгалт явуулах дараалал, шалгалтын мөрөөр авах арга хэмжээний талаар тус тус тусгасан болно.

Журмын төсөлд Захиргааны ерөнхий хуулийн 61-дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт заасны дагуу Захиргааны хэм хэмжээний актын төсөлд нөлөөллийн шинжилгээ хийж, танилцуулга холбогдох мэдээллийн хамт боловсруулав.

---Оо---

ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРМЫН ТӨСӨЛД ХИЙСЭН НӨЛӨӨЛЛИЙН ШИНЖИЛГЭЭ

1. Журам батлуулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцуудын техникийн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг хангаж, хүрээлэн буй орчныг бохирдуулах эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, холбогдох олон улсын гэрээ, конвенцын шаардлагыг биелүүлэх нь далбааны эзэн улсын үүрэг юм.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцуудад далбааны эзэн улсын зүгээс Далайн захиргаа хяналт, шалгалт хийхээс гадна бусад орны боомтын хяналтын албанда хөлөг онгоц saatuuulagdsan тохиолдолд зөрчлийг хэрхэн арилгасан байдалд хяналт, шалгалт явуулж аюулгүй ажиллагааны хүрээнд холбогдох арга хэмжээ авч, хэрэгжүүлэн ажиллаж байна.

Олон Улсын Далайн Байгууллагаас Монгол Улсын далайн тээврийн салбарт хийсэн аудитын шалгалтын зөвлөмжөөр өөрийн улсад бүртгэлтэй хөлөг онгоцонд хяналт шалгалт хийх хууль эрх зүйн орчин бурдүүлэх шаардлагатайг онцолсон.

Далай ашиглах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.10-т “Далбааны эзэн улсын хяналт, шалгалт хийх журмыг далайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална” гэж заасан.

2. Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц болон багийн бүрэлдэхүүн олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжид заасан шаардлага хангаж байгаа эсэхэд далбааны эзэн улсын зүгээс хяналт, шалгалт хийх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

Уг журмын төсөл нь 14 бүлэг, 79 заалтаас бүрдэнэ.

Далай ашиглах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т заасны дагуу эрх олгогдсон далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагч, мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-т заасны дагуу Далайн захиргаанаас томилогдсон далайн эрэг бүхий улсын хянан шалгагч хяналт, шалгалт хийхэд энэ журмыг дагаж мөрдөнө.

3. Журмын төсөл батлагдсаны дараа хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Журмын төсөл батлагдсаны дараа далайн тээврийн үйлчилгээ эрхэлж буй хувь хүн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь ямар нэг байдлаар хөндөгдөхгүй.

4. Хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл бурдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Энэхүү журмын төсөлд хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад учруулсан, аливаа хүнд суртал, авлига үүсэх нөхцөл бүрдүүлсэн зохицуулалт агуулаагүй болно.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх, тушаалыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүү эдийн засгийн тогтолцоо

Журмын төсөлд тусгагдсан харилцааг зохицуулсан эрх бүхий байгууллагаас баталсан эрх зүйн акт байхгүй болно.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоцны хяналт шалгалт хийх ажиллагааг далбааны эзэн улсын зүгээс Далайн захиргааны Хөлөг онгоцны бүртгэл, хяналтын алба хариуцан хэрэгжүүлдэг. Иймд энэхүү журмыг хэрэгжүүлэхэд шинээр хүний нөөц шаардагдахгүй бөгөөд Далайн захиргааны одоогийн орон тоо, төсөвт багтаан хэрэгжүүлнэ.

Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоцонд хяналт шалгалт хийх ажиллагаанд шаардлагатай зардлыг Далай ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.15-д “хөлөг онгоцны бүртгэлийн үйлчилгээний орлогын 20-иос доошгүй хувийг хууль тогтоомжийн хүрээнд далбааны эзэн улсын хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан захиран зарцуулах” гэж заасны дагуу хөлөг онгоцны бүртгэлийн орлогоос Далайн захиргааны үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөнд жил бүр тусган санхүүжүүлэх бүрэн боломжтой.



Зам, тээврийн хөгжлийн сайдын
2023 оны 03 дугаар сарын 31...-ны өдрийн
A/92 дугаар тушаалын хавсралт

ДАЛБААНЫ ЭЗЭН УЛСЫН ХЯНАЛТ, ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц болон багийн бүрэлдэхүүн олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжид заасан шаардлага хангаж байгаа эсэхэд далбааны эзэн улсын зүгээс хяналт, шалгалт (цаашид "хяналт, шалгалт" гэх) хийх үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

1.2. Далай ашиглах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-т заасны дагуу эрх олгогдсон далбааны эзэн улсын хяналтын улсын байцаагч (цаашид "улсын байцаагч" гэх), мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.5-т заасны дагуу Далайн захиргаанаас (цаашид "Захиргаа" гэх) томилогдсон далайн эрэг бүхий улсын хянан шалгагч (цаашид "хянан шалгагч" гэх) хяналт, шалгалт хийхдээ энэ журмыг дагаж мөрдөнө.

1.3. Улсын байцаагч, хянан шалгагч нь Далай ашиглах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т заасан чиглэлээр хяналт, шалгалт хийнэ.

Хоёр. Улсын байцаагч, хянан шалгагч, түүний эрх, үүрэг

2.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь Далай ашиглах тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь заалтад заасан ерөнхий шаардлагуудыг хангасан байна.

2.2. Хөлөг онгоцны техникийн болон холбогдох бусад сургалтын хөтөлбөрт хамрагдаж онолын болон дадлагын мэдлэг эзэмшсэн, мэргэжлийн ур чадварын гэрчилгээтэй байна.

2.3. Хөлөг онгоцны тавцан өөд авирах, буух, хөлөг онгоцны хөдөлгүүр болон ачаа хадгалах ёроолын хэсэгт орж хяналт, шалгалт хийх зэрэг биеийн хүч шаардсан хөдөлгөөн хийхэд эрүүл мэндийн хувьд тохирохуйц байна.

2.4. Далайн боомтын хил, гааль, Монгол Улсын төрийн далбаа мандуулсан хөлөг онгоц дээр чөлөөтэй нэвтрэх эрх бүхий үнэмлэх, дүрэмт хувцастай байна.

2.5. Хяналт, шалгалтыг хууль тогтоомжоор олгосон бүрэн эрхийн хүрээнд хийж, хууль дээдлэх зарчмыг баримтлан аливаа шийдвэрийг хараат бусаар олон улсын гэрээ, конвенц болон хууль тогтоомжид нийцүүлэн гаргана.

2.6. Хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчлийг таслан зогсоох, түүний шалтгаан, нөхцөлийг арилгах талаар хөлөг онгоц эзэмшигч, ахмадад шаардлага тавьж, хугацаатай үүрэг, даалгавар өгч биелэлтийг хангуулах үүрэгтэй.

Гурав. Хяналт, шалгалтад бэлтгэх

3.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт, шалгалтын удирдамж боловсруулан батлуулж, хяналт, шалгалтын бүртгэл, мэдээллийн санд оруулж дугаар авна.

3.2. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт, шалгалт хийх гэж буй хөлөг онгоцыг далайн боомтод ирэхээс өмнө тухайн хөлөг онгоц эзэмшигч болон түүний төлөөлөгч, хөлөг онгоцны ахмадтай холбоо барьж урьдчилан мэдэгдэнэ.

3.3. Хөлөг онгоцны ахмадаас боомтод ирэхээр төлөвлөсөн хугацаа болон дараагийн боомт руу аялахаар төлөвлөж буй хугацааны талаар урьдчилан мэдээлэл авна.

3.4. Улсын байцаагч нь хөлөг онгоцны байршил тогтоох хянах системийг ашиглан хяналт, шалгалт хийх гэж буй хөлөг онгоцны байршлыг тогтмол хянан шалгаж баталгаажуулна.

3.5. Хөлөг онгоцны эзэмшигч, төлөөлөгч нь Далай ашиглах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2-т заасны дагуу улсын байцаагч, хянан шалгагчийг хөлөг онгоцон дээр хяналт, шалгалт явуулахад шаардагдах, хил гааль, боомтод нэвтрэхэд шаардлагатай зөвшөөрлүүдийг авсан байна.

Дөрөв. Хяналт, шалгалтыг эхлүүлэх

4.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь Захиргаанаас баталсан хяналтын хуудаст холбогдох хөлөг онгоцны мэдээлэл, шалгалт явуулж буй боомтын нэр, огноог тэмдэглэн хяналт, шалгалтыг эхлүүлнэ.

4.2. Улсын байцаагч, хянан шалгагч нь хөлөг онгоцны багийн бүх гишүүд онгоц дээр байх үед болон хөлөг онгоцны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр хяналт, шалгалт хийнэ.

4.3. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт шалгалт хийхдээ хөлөг онгоцны бүртгэлийн тэрчилгээ болон шаардлагатай бичиг баримт, мэдээллийг хөлөг онгоцны ахмадаас гаргуулан авна.

Тав. Хяналт, шалгалтыг гүйцэтгэх

5.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт, шалгалтын удирдамж, хяналтын хуудасны хүрээнд хөлөг онгоц дээрх хяналт, шалгалтыг тухайн хөлөг онгоцны овор, хэмжээ, даацнаас хамааран ажлын нэгээс хоёр хоногийн хугацаанд бүрэн гүйцэд хийнэ.


5.2. Хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг холбогдох хууль, олон улсын гэрээ, конвенцод заасны дагуу авч хэрэгжүүлнэ.

5.3. Хяналт шалгалт хийх явцад илэрсэн зөрчил дутагдлыг гэрэл зураг, дуу, дүрсний бичлэг зэрэг боломжит арга хэрэгслээр баримтжуулж хяналтын хуудас болон хяналт шалгалт хийсэн тайланд хавсаргана.

5.4. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналтын хуудсыг 2 хувь үйлдэж, нэг хувийг хөлөг онгоцны ахмадад өгнө.

Зургаа. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагаанд хяналт, шалгалт хийх

6.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт шалгалт хийхдээ хөлөг онгоцны ахмад болон багийн гишүүд хөлөг онгоцны техникийн аюулгүй ажиллагааг хангах, осол аваарт өртөх, багийн гишүүдийн амь нас, далайн хүрээлэн буй орчин,



өмч, хөрөнгөд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх хөлөг онгоцны Аюулгүй ажиллагааны менежментийн системийн хэрэгжилтэнд нэн тэргүүнд хяналт шалгалт хийнэ.

6.2. Улсын байцаагч, хянан шалгагч нь хөлөг онгоцны аюулгүй ажиллагааны дагуу дараах хяналт, шалгалтыг хэрэгжүүлнэ.

6.2.1. хөлөг онгоцны ахмад нь аюулгүй ажиллагааны менежментийн үүрэг, хариуцлагаа ухамсарлан ойлгож, түүнийг хэрэгжүүлж байгаа эсэх;

6.2.2. Аюулгүй ажиллагааны менежментийн гарын авлага нь хөлөг онгоцны тавцан дээрх багийн гишүүдэд танилцахад нээлттэй байх;

6.2.3. ахмад нь аюулгүй ажиллагааны менежментийн хүрээнд нэн тэргүүнд хэрэгжүүлэх арга хэмжээгээ тодорхойлж чадаж байгаа эсэх;

6.2.4. гэнэтийн ослын үед холбоо тогтоох, мэдэгдэх талаарх журам байгаа эсэх;

6.2.5. Аюулгүй ажиллагааны менежментийн шаардлагын дагуу хөлөг онгоц эзэмшигчээс дотоод хяналт хийгдсэн эсэх;

6.2.6. зөрчил дутагдал, аюул ослын тохиолдлын талаар хүлээн зөвшөөрөгдсөн байгууллагад мэдээлсэн тухай тайлан байгаа эсэх;

6.2.7. гол хөдөлгүүр, туслах хөдөлгүүр ба бусад тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг шалгаж, тэмдэглэл хөтөлдөг эсэх,

6.2.8. хүний амь нас, хүрээлэн буй орчныг хамгаалах, түүнчлэн галын аюулгүй байдал, гал унтраах хэрэгслийн засвар үйлчилгээг шалгасан талаар тэмдэглэл хөтөлдөг эсэх,

6.2.9. ахмад нь хөлөг онгоц боомтод нэвтрэх, боомтоос гарах үеийн аюулгүй ажиллагааны хяналтын хуудас ашигладаг эсэх, ачаа ачих, буулгах үеийн аюулгүй ажиллагааны журмын хэрэгжилтийн байдлыг шалгаж тэмдэглэл хөтлөдөг эсэх.

Долоо. Хөлөг онгоцны бүртгэлийн болон далайчны чадамжийн гэрчилгээнд хяналт, шалгалт хийх

7.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь хөлөг онгоц болон багийн гишүүдэд олгосон бүх гэрчилгээг нэг бүрчлэн нягтлан шалгана. Хэрэв аль нэг гэрчилгээний хугацаа дууссан нь тогтоогдвол гэрчилгээг яаралтай сунгах эсхүл цаашид авах шаардлагатай арга хэмжээг хяналт, шалгалтын тайланд тусгасан байна.

7.2. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэлтэй хөлөг онгоц нь дараах гэрчилгээнүүдийг хөлгийн тавцан дээр заавал авч явах шаардлагатай.

7.2.1. бүртгэлийн гэрчилгээ;

7.2.2. багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээ;

7.2.3. радио холбооны гэрчилгээ;

7.2.4. хөлөг онгоцны нэр, дуудлагын дугаар тэмдэглэлийн гэрчилгээ,

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯМ

ЭХ ХУВЬ

Сайд Ториин нариин бичгийн
дэргэ 1023 1/92
дараах тусгасан байна

7.2.5. далайчны чадамжийн гэрчилгээ;

7.2.6. техникийн гэрчилгээнүүд.

7.3. Энэхүү журмын 11.2-т заасан гэрчилгээнүүд нь хөлөг онгоц дээр байхгүй тохиолдолд улсын байцаагч, хянан шалгагч нь тухайн бичиг баримтын бүрдлийг хангаж ажиллахыг хөлөг онгоцны ахмад болон эзэмшигчид мэдэгдэнэ.

7.4. Гэрчилгээнүүдийн олгосон болон дуусах хугацааг хяналтын хуудсанд тэмдэглэнэ.

7.5. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт, шалгалт явуулж буй хөлөг онгоцны багийн бүрэлдэхүүний жагсаалтыг хөлөг онгоцны ахмадаас авч хяналтын хуудсанд хавсаргана.

7.6. Хөлөг онгоцны багийн гишүүд тухайн албан тушаалын зэрэгт тохирсон чадамжийн гэрчилгээтэй эсэхэд хяналт, шалгалт хийнэ.

7.7. Тухайн ажлын байранд ажиллаж буй далайчин нь холбогдох олон улсын гэрээний шаардлагад нийцсэн гэрчилгээ, бичиг баримт байхгүй эсхүл далбааны эзэн улсаас чадамжийн гэрчилгээ олгоогүй тохиолдолд нэн яаралтай гэрчилгээжүүлэх шаардлагыг хөлөг онгоцны ахмад болон эзэмшигчид тавина.

7.8. Хөлөг онгоцны аюулгүй ажиллагааг хангах үүрэг бүхий багийн гишүүдийн тооны доод хязгаарыг тогтоохдоо Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай конвенцод заасан шаардлагад тохирох түвшний үүргийг харгалзан үзсэн байна.

7.9. Хөлөг онгоц дээр ажиллах багийн гишүүдийн тооны доод хязгаар нь багийн гишүүдийн аюулгүй ажиллагааны гэрчилгээтэй нийцэж байх ёстой.

Найм. Багийн гишүүдийн ажиллаж, амьдрах нөхцөлд хяналт, шалгалт хийх

8.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь багийн гишүүдийн ажиллаж, амьдрах нөхцөлд хяналт, шалгалт хийхдээ амьдарч буй өрөөний зохион байгуулалт, бүтэц, ашиглалт, хангамжийн нөхцөл байдалд давхар хяналт, шалгалт явуулж болно. Хяналт шалгалтаар дараах зүйлсийг анхаарна. Үүнд:


8.1.1. өрөөний зохион байгуулалт, хана, шал, таазны өнгөлгөө болон дулаалгад ашигласан материал нь дуу чимээ, чичиргээнээс тусгаарлагдсан, эрүүл ахуйн орчныг бүрдүүлэхэд тохирсон байх;

8.1.2. агааржуулалт болон халаалт хэвийн ажиллагаатай эсэх;

8.1.3. гэрэлтүүлэг бүрэн бүтэн ажиллагаатай, хүртээмжтэй эсэх, тоноглол болон хамгаалалт нь бүрэн, эвдрэл, гэмтэл байгаа эсэх;

8.1.4. аваарын гарц саадгүй, чөлөөтэй орж, гарах боломжтой эсэх, гарцын тэмдэглэгээ нь тодорхой, ойлгомжтой байдлаар тэмдэглэгдсэн эсэх;

8.1.5. эрүүл ахуй бие засах өрөө, угаалгын өрөөнүүд шаардлагатай усны нөөцөөр хангагдсан, цэвэр эсэх, мөн ариун цэврийн, бохирын хоолойнууд бүрэн бүтэн, цоорч, гоожсон эсэх, тэмдэг, тэмдэглэгээ байгаа эсэх,



8.1.6. ундын усны хангамжийн зохицуулалт хүртээмжтэй эсэх;

8.1.7. гал тогоо, хооллох ундаах цайны өрөө, хүнсний агуулах – цэвэрлэгээ, ерөнхий нөхцөл байдал, утаа, хиншүү сорогч, тос шүүгчийн цэвэрлэгээнд анхаарах, мөн гал унтраах багаж, хэрэгсэл хангалттай байгаа эсэх;

8.1.8. багийн гишүүдийн амралт чөлөөт цагаа өнгөрөөх өрөөнд эрүүл мэнд дасгал хөдөлгөөнийг дэмжих тоног төхөөрөмжөөр тоноглогдсон эсэх;

8.1.9. сургалт, засвар, үйлчилгээний талаар багийн гишүүдэд танилцуулах гарын авлага зэргийг ашигладаг эсэх.

Ес. Хяналт, шалгалтыг дүгнэх

9.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь хөлөг онгоц дээр хяналт шалгалт хийсэн хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хяналтын хуудаст тэмдэглэсэн баримтыг үндэслэн дүгнэлт гаргана.

9.2. Хяналтын хуудаст илэрсэн зөрчил дутагдал болон хяналт шалгалтын дүгнэлтийг хөлөг онгоцны ахмадад танилцуулан гарын үзэг зурж, тэмдэг даруулан баталгаажуулан өгнө.

9.3. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт шалгалт хийсэн ажлын тайлан, хяналт шалгалтын үр дүнгийн талаар удирдах болон дээд шатны албан тушаалтанд танилцуулна.

9.4. Шалгалтын дүн эцэслэн гарсны дараа улсын байцаагч хяналт шалгалтын талаарх тайлан, мэдээллийг хөлөг онгоцны оноосон нэр, бүртгэлийн дугаар, ОУДБ-ын дугаар тус бүрээр хөлөг онгоцны бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд оруулна.

Арав. Хяналтын хуудас

10.1. Хяналтын хуудасны загварыг Засгийн газрын 2022 оны 479 дүгээр тогтооолоор батлагдсан "Хяналт шалгалт хийх нийтлэг журам"-ын 161-т заасны дагуу Захиргаа батална.

10.3. Улсын байцаагч, хянан шалгагч нь хяналт шалгалт хийх батлагдсан хяналтын хуудаст заасан асуудлын хүрээнд хийнэ.


10.4. Хяналтын хуудсыг бүрэн гүйцэд дэлгэрэнгүй бөглөсөн байх бөгөөд хэрэв тэмдэглэл хийгдээгүй бол шалтгаанаа тайлбарласан байна.

10.5. Улсын байцаагч, хянан шалгагчийн илрүүлсэн зөрчлийг хяналтын хуудсанд заавал тэмдэглэх бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хавсаргаж болно.

10.6. Хяналтын хуудаст тэмдэглэсэн зөрчлийн талаар хөлөг онгоцны ахмадад мэдэгдэх бөгөөд зөрчлөө нэн яаралтай арилгах арга хэмжээ авах талаар үүрэг болгоно.

Арван нэг. Фото зургаар баримтжуулах

11.1. Улсын байцаагч, хянан шалгагч нь хөлөг онгоцны дараах хэсгийн фото зургийг баримтжуулан хяналтын хуудсанд хавсаргана.



11.1.1.хөлөг онгоцны оноосон нэр, ОУДБ-ын дугаар болон холбогдох тэмдэглэгээг харуулсан хэсэг,

11.1.2.хөлөг онгоц бүхэлдээ харагдах байдал,

11.1.3.хөлөг онгоцны урд болон хойд хэсгийн тавцан,

11.1.4.удирдлага, жолоодлогын навигацийн өрөө,

11.1.5.багийн гишүүдийн амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх өрөө,

11.1.6.гол хөдөлгүүр, аваарын нэмэлт хөдөлгүүр, түүний эд анги,

11.1.7.хөдөлгүүрийн удирдлага хяналтын өрөө,

11.1.8.аливаа зөрчил, дутагдлыг баримтжуулсан зураг гэх мэт.

Арван хоёр. Бoomтын хяналтын албаны үзлэг, шалгалт

12.1. Бoomтын хяналтын албаны үзлэг, шалгалтаар хөлөг онгоц saatuuulagdsan эсхүл тухайн үзлэг, шалгалт нь далбааны эзэн улсын хяналт, шалгалттай зэрэг хийгдэж зөрчил илрүүлсэн бол улсын байцаагч, хянан шалгагч нь боомт улсын үзлэг, шалгалтаар илрүүлсэн бүх зөрчлийг нягтлан давхар шалгах бөгөөд тухайн зөрчил бүрт тэмдэглэл хөтлөн хяналтын хуудсанд тэмдэглэнэ.

12.2. Бoomтын хяналтын албаны үзлэг, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгасан эсэх, цаашид хөлөг онгоцонд ямар засвар үйлчилгээ шаардлагатай талаарх мэдээллийг улсын байцаагч, хянан шалгагч нь хяналтын хуудсанд тэмдэглэнэ.

Арван гурав. Хөлөг онгоц saatuuulaх

13.1. Монгол Улсын хөлөг онгоцны бүртгэлд бүртгэгдсэн хөлөг онгоц далайн тээврийн аюулгүй байдал, далайг бохирдуулахаас урьдчилан сэргийлэх талаарх олон улсын гэрээ, конвенц, хууль, тогтоомжийн дагуу техникийн аюулгүй ажиллагаагааг бүрэн хангаагүй эсхүл аливаа шаардлагыг зөрчсөн тохиолдолд далбааны эзэн улс уг хөлөг онгоцыг saatuuulж болно.

Арван дөрөв. Бусад

14.1. Энэхүү журмыг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

---оОо---

